


Ээлжит хичээлээр сурагчдын эзэмшсэн мэдлэг, чадварыг

**“Амжилтын үнэлгээ”-ний хуудсаар үнэлэх**

1. Битүү савтай шингэнийг 20 кПа даралтаар шахав. Савны хананд ямар даралт учрах вэ?
  - a. Даралт учрахгүй
  - b. Доод хананд 20 кПа даралт учирна.
  - c. 20 кПа даралт учирна.
  - d. Зөвхөн хажуу хананд даралт учирна.
2. Шингэн даралтыг хэрхэн дамжуулдаг вэ?
  - a. Зөвхөн дээшээ
  - b. Дээшээ ба доошоо
  - c. Зөвхөн доошоо
  - d. Бүх чигт
3. Автомашины тоормосны систем нь шингэний ямар шинж чанарыг үндэслэсэн бэ?
  - a. Шингэн шахагдахгүй. Даралтыг зүг бүртээ дамжуулдаг.
  - b. Шингэн нягт ихтэй. Даралтыг зүг бүртээ дамжуулдаг.
  - c. Шингэн урсамтгай. Даралтыг зөвхөн хажуу тийш дамжуулдаг.
  - d. Шингэн савныхаа хэлбэрийг дагадаг. Даралтыг зөвхөн дээш дамжуулдаг.
4. 1 дм талтай шоо хэлбэртэй саванд дүүртэл ус хийсэн шингэнийг бүлүүрийн зүгээс 2 кПа даралтаар дарж байв. Шингэний жинг тооцохгүйгээр савны дээд, доод, хажуу хана тус бүрд шингэний зүгээс ямар даралт учрах вэ?
  - a. Доод талд 2 кПа
  - b. Бүх хананд ижил 2 кПа
  - c. Хажуу талд 2 кПа
  - d. Бүх хананд ижил 8 кПа
5. Машины шингэнт тоормосны ажиллах зарчмыг зурагт үзүүлэв. Харгалзах дугаарт эд ангиудын нэрийг зөв харгалзуулна уу.

Шингэнд даралт хэрхэн дамжих вэ?



1

2

3

4

5

6

Тоормосны шингэн

Бүлүүртэй цилиндр

Татах пүрш

Тоормосны бүл

Тоормосны гишгүүр

Тоормосны гишгүүр